

Хавар

Зохиолч Д.Наваансүрэн

Шүлгийг сонсонгоо гүйлгэн уншаарай.

Хавартай би найзална даа

Хамт гадаа тоглоно доо

Усны шувууг угтана даа

Уран зэрэглээг харна даа



Хавартай би найзална даа

Хамт ажлаа хийнэ дээ

Зүлэг модоо усална даа

Шүлэг номоо уншина даа

Хавартай би найзална даа

Хамт хөдөө очно доо

Тариа ногоо тарина даа

Тараг айраг ууна даа



Хавартай би найзална даа

Хамт гадаа тоглоно доо

1. Асуултанд хариулаарай.

Усны шувууд хэзээ ирдэг вэ?

.....

Хавар ямар ямар ногоо тарьдаг вэ?

.....

2. Үгийн сүлжээг бөглөөрэй.

АЙРАГ

ТАРИА

УСНЫ ШУВУУ

ХАВАР

ТАРАГ

ЗЭРЭГЛЭЭ

МОД



2, 3, 4 сар - хавар

8, 9, 10 сар - намар

5, 6, 7 сар - зун

11, 12, 1 сар - өвөл

Намайг _____ гэдэг.

Би _____ сард _____ улиралд төрсөн.

3. Зургийг тохирох улиралтай холбоорой.



Хавар



Намар



Өвөл



Зун

